# Гурванзагал сумын сургууль








# 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТЫН ТАЙЛАН

# Сургуулийн танилцуулга

| СУРАГЧ | БАГШ, АЖИЛЧИН | МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ-ТЭРГҮҮЛЭХ | БОЛОВСРОЛЫН ЗЭРЭГ-МАГИСТР |
|---|---|---|---|
| 175 | 38 | 64% | 50% |

# Статистик үзүүлэлт







| Мэргэжил | Хангагдвал зохих багшийн тоо | Хангагдсан багшийн тоо |
|---|---|---|
| Бага анги | 5 | 5 |
| Математик, мэдээлэл зүй | 1 | 1 |
| Монгол хэл, уран зохиол | 1 | 1 |
| **Байгалийн ухаан** | 1 | 1 |
| Гадаад хэл | 1 | 1 |
| **Түүх, нийгмийн ухаан** | **1** | **1** |
| Дизайн технологи | 1 | 1 |
| Хөгжим, эрүүл мэнд | 1 | 1 |
| Дотуур байрны багш | **1** | **1** |
| Насан туршийн боловсролын багш | 1 | 1 |
| Биеийн тамир | 1 | 1 |
| Нийт | 15 | 15 |

## 1. Суралцагч зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй, бэлэн байдлыг хангах




### EDUTEN

### MEDLE.MN

### PEARSON

### CHADLAA.MN

- ✓ Багш болон суралцагчийн өөрийн үнэлгээний цогц систем бөгөөд хүссэн үедээ өөрийн мэдлэг чадварын түвшинг тогтоох боломжтой. 6-9 дүгээр ангийн сурагчид 100% , 1-5 дугаар ангийн сурагчдын 60% ашиглаж сурсан.

### SURAAD.MN

- ✓ Математикийн цахим сургалтын систем бөгөөд 6-9-р ангийн 30 сурагчдад амжилттай хэрэгжүүлсэн. Ирэх хичээлийн жил 100% ашиглаж сурах төлөвлөгөөтэй байна.

### ZANGIA AUDIO

- ✓ Хаанаас ч, ямар ч цаг үед монгол хэл дээр үнэгүй сонсож, унших боломжтой аудио ном, аудио хичээл, подкастын нэгдсэн платформ юм. Энэ хичээлийн жилд 7-р ангийн суралцагчид туршин хэрэгжүүлсэн бөгөөд хичээлийн жилийн эцэст уншаад ойлгон, ярих чадвар 30-40% ахисан.

**Суралцагч зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй, бэлэн байдлыг хангах**











## 2. Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, тэгш хамруулан сургах, тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах

### 1. Ялгаатай хэрэгцээг тодорхойлох, тэгш хамран сургах

- Тархины доод мөчдийн саажилт болон харааны бэрхшээлтэй 2 суралцагч суралцсан.

### 2. Сургалтад хамрагдах

Тэгш хамрран сургах сургалтад анги удирдсан болон мэргэжлийн багш нар хамрагдсан.

### 3. Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр

Дэмжлэгийн багаараа багш нарын ганцаарчилсан сургалтын хөтөлбөртэй танилцаж журмын дагуу нэмэгдэл цалин хөлсийг олгосон.

### 4. Сургалтын хэрэглэгдэхүүн болон орчин бүрдүүлэлт

- Хөгжлийн онцлогтой суралцагчийн орох, гарах замын налуу шатыг хийж гүйцэтгэсэн.
- Тухайн суралцагч нарын онцлог хэрэгцээнд тохирсон уншаад ойлгох, хараад ярих зэрэг чадварыг хөгжүүлэх 3D ном, хүүхэлдэйн театрыг хийсэн.

### 5. Сурлагын хоцрогдлыг нөхөх

- Түүх, нийгмийн ухааны хичээлийн хоцрогдлыг арилгах хөтөлбөр боловсруулан нэмэлт цагийн хуваарь гаргасан.
- "Гэртээ туршъя" байгалийн ухааны туршилтын багцуудыг авч хичээл сургалтын үйл ажиллагаандаа туршин хэрэгжүүлсэн.
- Өмнөх оны гүйцэтгэлийн үнэлгээний дата мэдээлэлд агуулгын анализ хийж, төлөвлөгөө боловсруулан ажилласан.

### 6. Сурлагын ахиц, амжилт

Сурлагын амжилт анги бүрийн түвшинд 10-20 хувиар ахиж, аймаг болон бүсийн уралдаан, тэмцээн, олимпиадад амжилт үзүүлсэн.

# СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН







Уншаад ойлгох, хараад ярих чадварыг хөгжүүлэх сургалын хэрэглэгдэхүүн







“Гэртээ туршъя” туршилтын хэрэглэгдэхүүн

# АМЖИЛТ ГАРГАСАН СУРАЛЦАГЧИД





















# АМЖИЛТ ГАРГАСАН БАГШ НАР













Дорнод аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, багш нарын дунд "Оюунлаг ирээдүйг хамтдаа бүтээцгээе" уриан дор зохион байгуулагдсан "Сэтгэх чадвар"- 2024 онлайн уралдаанд бага ангийн багш С.Оргилтуяа амжилттай оролцож, ТЭРГҮҮН БАЙР эзэллээ.

## 3. Байгууллагын менежментийн төлөвлөлт, цэцэрлэг, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох

**2024 онд аймгийн хэмжээнд сургуулийн менежментийг сайжруулах 8 сургуулийн 1 сонгогдож, сургуулийн менежментийг сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн.**

- Сургуулийн менежментийн загварт тусгагдсан сургуулийн онцлогт тулгуурласан ажлуудын хэрэгжилт зэрэг болно.
- Сургуульд суурилсан менежмент онлайн вебинар сургалт
- Зөвлөн туслах багийн өгсөн зөвлөмжийн дагуу загасан нуруу, менежментийн зураглал, сургуулийн эрхэм зорилго, уриа, алсын харааг засан сайжруулалт
- Сургуулийн өөрийн ба хөндлөнгийн үнэлгээний үр дүнд анализ хийн, асуудлаа илрүүлж, менежментийн зураглалдаа тусгасан байдалд БШУГ-аас томилогдсон багийн зөвлөн туслах үйл ажиллагаа
- Сургалтын түгээн дэлгэрүүлэлт, сургуулийн тулгамдсан асуудал /нөхцөл байдлаа тодорхойлох даалгавар, үйл ажиллагааны аргачлал, өөрийн үнэлгээ
- Боловсролын ерөнхий газраас аймгийн хэмжээнд сонгогдсон 8 сургуулийн менежментийн багт зохион байгуулсан “Сургуулийн менежментийг сайжруулах, зөвлөн туслах” сургалт

Зөвлөн туслах багийн өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу сургуулийн эрхэм зорилго, уриа, алсын хараагаа шинэчилж, загасан нуруу, менежментийн зураглалдаа засан сайжруулалт хийж, хичээлийн жилийг дуустал хийж хэрэгжүүлэх орон нутаг болоод сургуулийн онцлогтой ажлуудыг төлөвлөлөө.

## АЛСЫН ХАРАА

Сайхан сэтгэл, эерэг хандлага, эрдэм боловсролтой хөгжсөн багшаас бие дааж бүтээлчээр суралцах арга барил эзэмшсэн чадварлаг суралцагчийг төрүүлнэ.

## ЭРХЭМ ЗОРИЛГО

ЗӨВ ДАДЛЫГ ЭРХЭМЛЭСЭН, ТЕХНОЛОГИЙН ЗӨВ ХЭРЭГЛЭЭТЭЙ, УХААРАН УНШИГЧ ХҮҮХЭД.

## СУРГУУЛИЙН УРИА

ЗӨВ УНШИЖ
ЗӨВ СУРАЛЦАЖ
ЗӨВ ХЭРЭГЛЭЭ

# ГУРВАНЗАГАЛ СУМЫН СУРГУУЛИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ



# ГУРВАНЗАГАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТ

## ДОРНОД АЙМГИЙН ГУРВАНЗАГАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТ

### БШУЯ-НЫ ЗОРИЛГО

Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан цэцэрлэг, сургуулийн менежментийг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гаргах арга барилыг сургалтад нэвтрүүлнэ.

### АЛСЫН ХАРАА

Сайхан сэтгэл, зэрэг хандлага, эрдэм боловсролтой хөгжсөн багшаас бие дааж бүтээлчээр суралцах арга барил эзэмшсэн чадварлаг суралцагчийг төрүүлнэ.

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Зөв дадлыг эрхэмлэсэн, технологийн зөв хэрэглээтэй, ухааран уншигч хүүхэд.

### СУРГУУЛИЙН УРИА

Зөв уншиж
Зөв суралцаж
Зөв хэрэглэе



### ХҮСЭЖ БУЙ ХҮҮХДИЙН ДҮР ТӨРХ

Хүнлэг сэтгэлтэй, хичээл зүтгэлтэй хүүхэд



### ХҮСЭЖ БУЙ БАГШИЙН ДҮР ТӨРХ

Суралцагчдаа ойлгодог, зөв хандлагатай, заах арга барилаа эзэмшсэн найз шиг багш

### СУРГУУЛИЙН ЗОРИЛГО

Зөв дадлыг эрхэмлэсэн, технологийн зөв хэрэглээтэй, ухааран уншигч хүүхэд.

### ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТУУД

1. Судлагдахуун тус бүрээр бие даан ойлгон унших чадварыг хөгжүүлэх
2. Цахим хэрэглээг зөв хэрэглэх технологийн чадварыг эзэмшүүлэх
3. Бусдад хүндэтгэлтэй ханддаг, өв соёлоо эрхэмлэсэн зөв хандлагатай хүүхдийг төлөвшүүлэх

### ТУЛГАМДСАН АСУУДАЛ 1:

Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр:

- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 9.6% ахисан
- Хүүхдийн хөгжил хамгаалал 26.8% ахисан
- Багш, ажилтны тасралтгүй хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа 8.4%-иар буурсан
- Сургалтын орчин бүрдүүлэлт 2.1% ахисан
- Удирдлагын манлайлал, менежмент 2.2% ахисан
- Сургалтын байгууллагын талаарх сэтгэл ханамж 19.7% буурсан

### ТУЛГАМДСАН АСУУДАЛ 2:

- Сургалт, үйл ажиллагаанд хүүхдийн оролцоо идэвхийг нэмэгдүүлэх / ирц, идэвх, оролцоо /
- Сургуулийн орчинд бүдүүлэг үг хэллэг хэрэглэж, бие биедээ хүндэтгэлгүй харилцдаг, сургуулийн соёлоо мөрддөггүй 68%
- Бага, дунд ангийн суралцагчдын ойлгон унших чадвар 54%
- Эрүүл зөв дадалд суралцах шаардлагатай

### АСРАН ХАМГААЛАГЧИЙН ОРОЛЦОО

**Харилцаа**

-Хүүхдээ ойлгож, дэмжигч байх
-Хүүхдийнхээ хамтрагч байх
-Хүүхдэдээ үлгэрлэгч байх

**Хамтын ажиллагаа**

-Ахиц амжилтад үргэлж хамтдаа
-Аюулгүй байдалд үргэлж хамтдаа
-Асуудал шийдвэрлэхэд үргэлж хамтдаа

### ЗОРИЛТ 1:

**Судлагдахуун тус бүрээр бие даан ойлгон унших чадварыг хөгжүүлэх**

-Өдөр бүр 10 минутыг өөртөө уншлагын цаг
-Судлагдахуун тус бүр дээр суралцахуйн зорилтыг шинжилж, ээлжит хичээлд төлөвлөн ажиллах

### ЗОРИЛТ 2:

**Цахим хэрэглээг зөв хэрэглэх технологийн чадварыг эзэмшүүлэх**

-Сураад.mn платформыг сургалтад нэвтрүүлэн хэрэгжүүлж ажиллах
-Цахим хэрэглээг зөв хэвшүүлэх, нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулах

### ЗОРИЛТ 3:

**Бусдад хүндэтгэлтэй ханддаг, өв соёлоо эрхэмлэсэн зөв хандлагатай хүүхдийг төлөвшүүлэх**

-Зээрэнхий бөөрөнхэй бүжгийг сурах
-"Алдаж боломгүй-Алтан цаг" төлөвшүүлэх үйл ажиллагаа
-Барга дээлний өв соёлыг суралцагчид тайлбарлах чадвартай болгох контент, видео бичлэгийн уралдаан

### ОРОН НУТГИЙН ОРОЛЦОО, ДЭМЖЛЭГ

-Багшийн арга зүйг хөгжүүлэн дэмжин хамтран ажиллах
-Хүүхдийн сурч боловсрох эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэхэд хамтран ажиллах
-Мэргэжлийн чиг баримжаа олгоход олон нийтийн байгууллагатай хамтрах
-Сумын төсөвт албан байгууллагуудтай хамтран ажиллах

### ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

- Хүүхэд бүр хичээл эхлэхийн өмнө 10 минутын уншлага хийж, тэмдэглэл хөтөлж, бүтээлчээр хандсан байх
- Судлагдахуун бүрийн даалгаврын биелэлт, гүйцэтгэл хувь ахисан байх
- Сургуулийн орчинд аливаа хэлбэрийн дээрэлхэлт, зөрчил буурсан байх
- Эцэг эх, олон нийттэй хамтран суралцагчдыг тодорхой, зөв дадал хэвшүүлэх
- Зээрэнхий бөөрөнхий бүжиг болон барга дээлний өв соёлын талаар 175 сурагч, 38 багш ажилтан мэддэг болсон байх
- Хичээлийн хоцрогдол, таслалтгүй, дүрэмт хувцсаа 100% өмсдөг анги хамт олон болсон байх
- Сураад.mn цахим платформыг хичээл сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байх

**Сургуулийн эрхэм зорилго, уриа, менежментийн зураглалд тусгагдсан шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.**

- ӨДӨР БҮР 10 МИНУТЫГ ӨӨРТӨӨ УНШЛАГЫН ЦАГ
- СУРГУУЛИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, УРИАГ СУРАЛЦАГЧ, БАГШ, АЖИЛТАН МӨРДЛӨГ БОЛГОХ
- ДЭВТЭР БОЛ СУРАЛЦАГЧИЙН ТОЛЬ ҮЙЛ АЖИЛЛАГАА
- АЛДАЖ БОЛОМГҮЙ- АЛТАН ЦАГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
- ЗЭЭРЭНХЭЙ, БӨӨРӨНХЭЙ ЗАВСАРЛАГААНЫ ДУУ, БҮЖИГ
- СУРААД.MN ПЛАТФОРМЫГ СУРГАЛТАД НЭВТРҮҮЛЭХ
- “ЗОЧИНТОЙ ХИЧЭЭЛ” ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Сургуулийн эрхэм зорилго, уриа, менежментийн зураглалд тусгагдсан шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх, сургуулийн тулгамдсан асуудлаа шийдвэрлэх зорилгоор судлагдахуун тус бүрээр сурагчдын унших чадварыг ахиулах олон талт үйл ажиллагааг зохион байгуулав.**



- ✓ Сургууль болон соёлын төвийн номын сангаар 100% үйлчлүүлсэн.
- ✓ Миний цүнхний ном ярилцлага 80-90%
- ✓ Том, жижиг номын богц бүтээсэн. 80-90%
- ✓ Гэр бүлийн уншлага 24 гэр бүл
- ✓ Номын эмч челенж 100%
- ✓ Дүрд тоглох, төлөөлөн унших чадварт ахиц гарсан

# Багш, ажилтан, суралцагчид сургуулийн эрхэм зорилго, уриаг мөрдлөг болгон ажилласан



## Барга үндэсний бүжиг “Зээрэнхэй, бөөрөнхэй” бүжгийг багш, ажилтан, суралцагчид 100% сурсан



## 4. Тэргүүлэх болон Зөвлөх багшийн манлайлал”-ыг дээшлүүлэх арга хэмжээ, ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш, ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх

### ЗӨВЛӨХ БАГШИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

МУ-ын зөвлөх багш, Хан-Уулын сургуулийн сургалтын менежер О.Мөнхгэрэл багштай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж зөвлөн туслах сургалтыг зохион байгуулсан

### АХМАД БАГШИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

- “Ахмад үеийн сургаал” нөлөөллийн ажил
- “Ахмад багшийн үзүүлэх хичээл”

### ТЭРГҮҮЛЭХ БАГШИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

- Шинэ залуу багшийг дагалдуулан сургах
- “Зочинтой хичээл” үйл ажиллагаа

### АЖИЛЧДЫН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ ХӨТӨЛБӨР

5 дугаар бүсийн ажилчдын туршлага судлах үйл ажиллагаа



## 5. Багш, ажилтан, албан хаагчдад стрессээс сэргийлэх, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах

### 1 АМТТАНТАЙ ЯРИЛЦЛАГА

Ээлжийн амралтаар өөрийгөө хэрхэн хөгжүүлж, үр бүтээлтэй амарсан болон тэдний сэтгэл зүйн байдлыг тандах, идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хичээлийн жилийн эхэнд уг арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээнд 16 багш, 20 ажилтан хамрагдав..

### 2 АХМАДАА ХҮНДЭЛЬЕ ХАМТ ОЛНЫ ЗОЛГОЛТ

Сургуулиас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад багш, ажилчдадаа хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулсан бол золголт зохион байгуулсан залуу багш, ажилчид
-Алаг мэлхий өрөх тэмцээн
-Морь уралдах тэмцээн
-Азын дөрвөн бэрх буулгах тэмцээн
-Гарын бэлэг солилцох үйл ажиллагаа
-Цахим мэндчилгээ дэвшүүлэх үйл ажиллагаа санаачлан зохион байгуулав

### 3 "МИНИЙ НУУЦ ТАНИЛ" НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Миний нууц танил арга хэмжээг талархал, уучлал, гэнэтийн бэлэг гэсэн агуулгын хүрээнд зохион байгуулж, хамт олны бие биедээ итгэх итгэлийг төрүүлэх, ойлголцохгүй байгаа байдлыг ойлголцуулахад анхаарч ёс зүйн зөвлөлтэй хамтран зохион байгууллаа. Арга хэмжээний үр дүнд үл ойлголцох байдал багасч, хамт олны дунд эерэг таатай уур амьсгал 80%-тай болсон болно.

### 4 СЭТГЭЛ ЗҮЙН ТРЕНИНГ СУРГАЛТ

Дотуур байрны 40 сурагчдад 5 дугаар сургуулийн сэтгэл зүйч Б.Өлзийжаргал "Сэтгэл заслын тренинг" үйлчилгээ үзүүлж ажиллав. Нийгмийн ажилтан М.Мөнх-Амьдрал 6-9 дүгээр ангийн 102 сурагчдад тренинг сургалтыг зохион байгуулав.

### 5 ОНЦГОЙ ӨДӨР

4 жилд 1 тохиох 2 сарын 29-ний өдөр Д.Дулмаа багштай 7а анги хамт олон ♥ "ОНЦГОЙ ӨДӨР" ♥♥♥ үйл ажиллагааг санаачлан ангиуд болон багш нарынхаа дунд зохион байгуулж, энэ өдрийг дурсамж дүүрэн тэмдэглэн өнгөрүүллээ.

### 6 АЖИЛЧДЫН БАЯР

Жил бүр багш нар сургуулийн далд уурхайн эрдэнэс болсон ажилтнуудаа баярлуулдаг уламжлалтай. Энэ жилийн хувьд сумын "Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн" зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан байгууллагын арыг албанд цаг наргүй ажилладаг тэднийгээ баярлуулж, багш нарын зүгээс дурсгалын зүйл гардууллаа.

ГУРВАНЗАГАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

# “АХМАДАА ДЭЭДЭЛЪЕ”

## хамт олны золголт

2024.02.13

6. Цэцэрлэг, сургууль, дотуур байрны орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагаар сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, сурах, хөгжих, төлөвших үйл явцыг дэмжих тусгайлсан арга хэмжээг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх, үр дүнг тооцох

## СУРГАЛТ

- ➢ “Сэтгэл заслын” тренинг үйлчилгээ /5-р сургуулийн сэтгэл зүйч Б.Өлзийжаргал/
- ➢ “Хувь хүний хөгжил” сургалт /Хүн болох багаасаа төслийн баг/




## ӨДӨРЛӨГ

- ➢ “Сургуульдаа тавтай морил”
- ➢ “Охидын өдөр”
- ➢ “Чи ганцаараа биш” аян
- ➢ “Хамтдаа хөгжье - Хамтдаа манлайлъя” өдөрлөг

## ЗӨВЛӨГӨӨН

- ➢ “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” суралцагчдын нэгдсэн зөвлөгөөн


ТРЕНИНГ
СУРГАЛТ


ТРЕНИНГ
СУРГАЛТ
Тренингийн дүрэм
1. Бусдыг хүндэтгэлтэй сонсох


Онцгой өдрийн онцгой азтангууд
Онцгой өдрийн онцгой хүмүүс
Анхааралтай сонсож байна уу даа
Бүгд аз жаргалтай...
Happy love
ОНЦГОЙ ӨДӨР
2024.02.29
ОНЦГОЙ ӨДӨР
Онцгой өдрийн онцгой хүмүүс


БАГШ ХӨГЖЛИЙН

# ӨДӨРЛӨГ

## “Сургуульдаа тавтай морил” 1

- Суралцагчдын сэтгэл зүйн таатай уур амьсгал бүрдүүлэх, сургуульдаа дасан зохицох зорилгоор уг арга хэмжээг зохион байгуулдсан.

## “Охидын өдөр” 2

- “Girl’s meeting” охидын уулзалт хэлэлцүүлгийг дунд ангийн эмэгтэй багш нар хариуцаж 6-9 дүгээр ангийн 45 охинд, 1-5 дугаар ангийн 57 охинд бага ангийн багш нар уг хэлэлцүүлгийг хийж тэдний санаа бодлыг сонсож, харилцаж ярилцсан байна. Ярилцлагын явцад охидууд хөвгүүд охидоо хүндэтгэж, зөв боловсон харилцаж байх, соёлтой байхад анхаарах, гэсэн саналыг ярилцлагад оролцсон нийт охидын 70% нь гаргасан байна

## “Чи ганцаараа биш” аян 3

- Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн төрөл хэлбэрүүдийг таньж мэдэх, тэдгээрээс хүүхдээ хамгаалах, урьдчилан сэргийлэх арга замууд, энэ төрлийн гэмт хэргийг мэдээлэх, тусламж үйлчилгээ авах арга хэрэгсэл, сувгуудын талаар мэдээлэл өгөх, өсвөр насны хүүхэд, эцэг эхчүүдийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлсэн.

## “Хамтдаа хөгжье - Хамтдаа манлайлъя” өдөрлөг 4

- Боловсролын салбарын болон байгууллагын үйл ажиллагааг эцэг эхчүүдэд сурталчлан таниулах, тэдний харилцаа, эерэг хандлагын дадал төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, багш нарын арга зүй, ур чадварыг тэдэнд таниулах зорилгоор зохион байгуулсан. Уг арга хэмжээнд 80 гаруй эцэг эх хамрагдсан.

Сурагчид нэг нэгнээ шоглохгүй, хүндэтгэлтэй хандах, сэтгэл хөдлөлөө хэрхэн тогтвортой байлгах арга зүйд суралцах чадварт суралцсан.

# “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” суралцагчдын зөвлөгөөн

**1**

1-5 дугаар анги **"Дээрэлхэл миний нүдээр"** гар зургийн уралдааны шилдэг бүтээлээ тайлбарлах

**2**

6-9 дүгээр анги **“Үе тэнгийн дээрэлхэл”** эссэ бичлэгийн тэргүүн байрын бүтээлийг уншиж танилцуулах

**3**

Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Аззаяа **“Хүүхэд хамгааллын талаар”** сум орон нутгийн хүрээнд хэрэгжүүлж буй бодлогын талаар

**4**

Сумын хэсгийн төлөөлөгч Р.Амгаланбат **“Үе тэнгийн дээрэлхэл”**-ийн талаар мэдээлэл өгөв.





Аймаг, бүсийн хэмжээнд амжилт гаргасан сурагчдаа алдаршуулсан.

Боловсролын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газраас улсын хэмжээнд зохион байгуулсан "ДЭЭРЭЛХЭЛ ДЭЛГЭРЭХ ЁСГҮЙ" аяны үйл ажиллагааг дэмжиж 1-9 дүгээр ангийн дарга нарт болон жижүүр багшид Гурванзагал Сумын Тамгын Газрын дэмжлэг тусламжтайгаар нэгэн жигд фудволка авч ангийн суралцагчдадаа нөлөөллийн ажлыг хийж хэвшлээ.
Сурагчдаас үе тэнгийн дээрэлхэлтийн талаар судалгаа авч нэгтгэхэд бие махбодийн дээрэлхэлт байдаггүй харин үг хэл, биеийн хэлэмжээр доромжлох зэрэг дээрэлхэлт байдаг гэсэн байна.



## 7. Байгууллагын орчны эрсдэлийг бууруулах, дотоод хяналтыг тогтмолжуулан, тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцох

1. Замын аюулгүй байдал, машины зогсоол, гарц тэмдэглэгээ хийх
2. Сургуулийн барилга, байгууламжийг сайжруулах, цаашлаад шинэ барилга барих
3. Орчны гэрэлтүүлгийг сайжруулах
4. Заалны халаалт болон анги танхимын тохижилт, дулааныг нэмэгдүүлэх
5. Золбин нохойн асуудлыг анхаарах
6. Гадаа талбайтай болох
7. Камержуулалт хийх

Сургуулийн хүүхэд хамгааллын багаар энэ хичээлийн жилийн эхэнд орчны аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж эрэмбэлэн, шалгуур үзүүлэлтээр гарсан 32 эрсдэлийг бууруулах ажлын төлөвлөгөөг боловсруулж 86 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.

# Байгууллагын орчны эрсдэлийг бууруулах, дотоод хяналтыг тогтмолжуулан, тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцох

Эрэмбэлэн жагсаасан дээрх саналуудтай холбогдуулан эхний хагас жилд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Анги танхимын дотоод орчны аюулгүй байдлыг сайжруулах

Дотуур байр болон сургуулийн гадаад болон дотоод орчны аюулгүй байдлыг сайжруулах

# Хийж хэрэгжүүлсэн ажил

**Сургуулийн эрсдэлийн үнэлгээ хийх 1**

Дорнод аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар 2023 оны 10 дугаар сарын 20-ны зөвлөн тусалж, арга зүйн дэмжлэг үзүүлсэн.

**Аюулгүйн зураглал 2**

Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/453 дугаар тушаалын хавсралт, аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргын 1/2389 албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор сургуулийн нийт суралцагчдын "Гэр-Сургууль" хүрэх замын АЮУЛГҮЙН ЗУРАГЛАЛ-ыг боловсруулсан.

**Орчны гэрэлтүүлгийг сайжруулах 3**

Сургуулийн гадна талын гэрэлтүүлгийг “ДОРНЫН ТУЛГАТ ӨРГӨӨ” ХХК хийж гүйцэтгэсэн.

**Камержуулалт хийх 4**

Сургуулийн орчны стандартын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сумын ОНХСангийн хөрөнгө оруулалт 12 сая төгрөгөөр сургуульд 11 камер, дотуур байранд 8 камерыг суурилуулсан.

**Мэдэгдэл хүргүүлэх 6**

Нохойтой айлуудад нохойгоо уях мэдэгдэл хүргүүлэх, нохой устгалын ажлыг яаралтай хийлгэх арга хэмжээнүүдийг авч, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх талаар 2023 оны 04 дүгээр сарын 14ны өдрийн №24 албан тоотыг сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн дарга Б.Бямбасүрэнд хүргүүлсэн.

- ✓ Спорт заалны орчин
- ✓ Цонх, хаалганы дулаалга
- ✓ Гадна талбайн аюулгүй байдлыг хангах
- ✓ Хүүхдийн аюулгүй орчныг бүрдүүлэх

# Хийж хэрэгжүүлсэн ажил

## Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээнүүдийг байршуулсан

1 Хурц ирмэгтэй, унах, хагарах болзошгүй зүйлүүд /цонх, шүүгээ, шүүгээний шилэн хаалт, ширээ, сандал, тавиур, хаалга, цонхны тавцан г.м

2 Цахилгааны аюулгүй байдлаас сэргийлж ангийн тогны залгуурыг хүүхэд гар хүрэх газраас өндөрт байршуулж анхааруулах тэмдгийг наасан.

## Тэмдэгдэл хөтөлж эхэлсэн

3 Ангийн агаар сэлгэлтийн талаарх тэмдэглэлийг тогтмол хөтлөх хавтас нээсэн.

4 Ангийн дулааныг хянах температур хэмжигчийг байршуулж, температурын өөрчлөлтийг тогтмол тэмдэглэх хавтас нээсэн.

5 Асахгүй байгаа гэрэлтүүлгийг солих, цахилгааны унжсан утаснуудыг далдалж янзалсан.

# Хийж хэрэгжүүлсэн ажил

- **5С зарчмыг баримтлан:**
  - ✓ Ангийн эд хогшлыг эмхэлж, цэгцлэн бүртгэн коджуулсан.
  - ✓ Сурагчийн сандал, ширээ бүрийг дэс дараагаар дугаарласан.
  - ✓ Ангид мөрдөх дэг, анхаарах зүйлсийн жагсаалтыг сурагчийн ширээ болгон дээр байршуулсан.
- Сурагчийн хөгжилд нөлөөлөхүйц орчин бүрдүүлэх
  - ✓ Завсарлагааны цагаар сурагчдын чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, засварлагаанаар ямар нэгэн эрсдэлд орж болзошгүй байх тал дээр анхаарч чөлөөт цагийн булан байгуулсан. Энэхүү булан нь сурагчдын сэтгэн бодох, оюун ухааны чадварыг хөгжүүлэх, Монгол уламжлалт тоглоом наадгай, хэл соёл, аман зохиолоос суралцах зэрэг тоглоом наадгай, ном зохиолоос бүрдсэн.

# Хийж хэрэгжүүлсэн ажлын дүгнэлт

“

5С зарчмыг дэвшүүлэн орчны эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа зохион байгуулж, хэрэгжүүлж, сайжруулснаар сайн ангилах, ялгах 92%, сайтар цэгцлэн зохион байгуулах 88%, сайхан цэвэрлэж, цэмцийлгэх 100%, стандартчилан хэвшүүлэх 96%, сахилга батыг төлөвшүүлэх 100% хүрч, үзүүлэлт бүр өмнөх байдлаасаа 13-20 хувиар ахицтай байгаа нь байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний сургалтын орчин үзүүлэлт улсын дундажтай ижил түвшинд хүрэх боломжийг нэмэгдүүлэхээс гадна хүүхдийн хөгжил, хамгаалал, аюулгүй байдал, эрсдэлийг бууруулсан танхим болон бий болсон.

”

## ДОРНОД АЙМГИЙН ГУРВАНЗАГАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН АЮУЛГҮЙН ЗУРАГЛАЛ



## Суралцагчдын сурч буй ангийн орчны аюулгүй байдалд эрсдлийн үнэлгээ хийж ангийн эд хогшилд анхааруулах тэмдэг тэмдэглэгээг байршуулсан




















# 5С_ЗАРЧМЫГ_ШИНГЭЭСЭН_АНГИ_ТАНХИМ_БҮТЭЭЛЧ_АЖЛЫН_УРАЛДААН



ӨМНӨ НЬ



ӨМНӨ НЬ



ӨМНӨ НЬ



ДАРАА НЬ



ДАРАА НЬ



ДАРАА НЬ

# 5С ЗАРЧМЫГ ШИНГЭЭСЭН АНГИ ТАНХИМ БҮТЭЭЛЧ АЖЛЫН УРАЛДААН








ӨМНӨ НЬ

ӨМНӨ НЬ

ӨМНӨ НЬ








ДАРАА НЬ

ДАРАА НЬ

ДАРАА НЬ

# 8. Шинэлэг, онцлог, бусдад туршлага болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээ

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Сумын 2023 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Биеийн тамирын гадна талбайг "Анд пирамид" констракшн хийж гүйцэтгэж хүлээлгэн өгөв.





Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хамтарсан хөрөнгөөр 245 сая төгрөгний өртөгтэй дотуур байрны дотоод их засварыг “Баян луу” ХХК нь хийж гүйцэтгэж байна.







**Өмнө нь**

Хогийг ангилж хаях, шатаах зориулалттай 2 хогийн савыг блокоор хийж гүйцэтгэв.





**Дараа нь**



Дотуур байрны гаднах агуулахын дээврийг бүрэн шинэчилж, сургуулийнхаа эд хогшлыг эвдрэл гэмтэлгүй хадгалах нөхцөл боломж бий болж байна





## Өвөлжилтийн бэлэн байдлыг бүрэн хангав.

Дотуур байрны В блокын сан болон сургуулийн анги танхим коридорын паарыг угааж, засаж сэлбэж янзлав.






Дотуур байрны нам даралтын зуухны насосыг шинээр тавьж, сургуулийн нам даралтын зуухны насосын эвдрэлийг засаж янзлав.





**Өмнө нь**



Бага ангийн багшийг дэмжих төслийн уралдааны оролцогч Д.Амарзаягийн дэмжлэгтэй сургуулийн үүдэн хэсэгт уншлагын булан байгуулж, хөгжлийн онцлогтой хүүхэд орох, гарах боломжтой налуу замыг хийж гүйцэтгэв.





**Дараа нь**



**Б.Сумьяа багштай “Ленгафон”**
**О.Билэгсайхан багштай “Мэдээлэл технологи”-ийн кабинет”**








**Сэтгэл зүрхээ зориулан шинийг санаачилж тохижуулсан**
**Э.Долгормаа, Б.Өнөрболд багштай “Дизайн технологи”-ийн кабинет**









Сургуулийнхаа коридорт хөшиг хийж, ханандаа монгол бичгийн ханын бичвэр бичүүлсэн.










Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаагаар 6-9 дүгээр ангийн охидууд гарын доорх материал ашиглаж, өөрсдийн хэрэгцээнд нийцсэн хувцсыг оёх, бүтээх ажлыг хэвшүүлж байна.













Дизайн технологийн багш Э.Долгормаагийн удирдан зохион байгуулдаг **ДАВСАН УРЛАЛ**-ын бүтээл манай сургуулийн брэнд бүтээгдэхүүн болж байна.













# НИЙГМИЙН АЖИЛТНЫ ТАЙЛАН ХАМГААЛАЛТ, АРГА ЗҮЙН ӨДӨРЛӨГ

Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны мэргэжлийн ажил үйлчилгээг сурталчлах, эерэг өөрчлөлтийг бий болгох, хамтын ажиллагааг сайжруулж, туршлага судлахад чиглэх зорилготой тайлан хамгаалалт, арга зүйн ажлыг ерөнхий боловсролын сургуулиудын 5 дугаар бүсийн сургуулиуд болох Хан-Уул, Гурванзагал, Баян-Уул, Баянтүмэн сургуулийн нийгмийн ажилтнууд 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдөр амжилттай зохион байгууллаа.






# 2024-2025 оны хичээлийг жил

## ОЛОЛТТОЙ ТАЛ

- “Сураад” цахим сургалтын хөтөлбөрийг ашиглаж эхлэх үндэс суурийг тавьсан.
- Сургуулийн менежментийн зураглалын дагуу ажилласнаар сурагчдын унших, бичих, бодох, мөн бие даан ажиллах чадвар 5-10% ахисан
- А пласын сургалтанд хамрагдсанаар сурагчдыг олон талаас нь нас сэтгэхүйн онцлогт тохируулан оношлох олон судалгааны аргуудыг сурсан.
- Үнэлгээний шалгуур зөвлөмжийн дагуу ялгаатай даалгавар боловсруулж сурсан.

*БАГШ НАРЫН БАГААР ХАМТРАН АЖИЛЛАХ ЧАДВАРТ АХИЦ ГАРСАН.*

**Энэ хичээлийн жилийн ололт амжилт цаашид анхаарах зүйл**

*СУРАГЧДЫН БИЕ ДААН СУРАХ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ*

## ЦААШИД АНХААРАХ ЗҮЙЛ

1. Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран хүүхдийнх нь хэрэгцээ, сонирхлыг судлах, хүүхдэдээ тавих анхаарлыг нэмэгдүүлэх
2. Ээлжит хичээл тус бүрийг чанартай бэлтгэж, үр дүнтэй заах
3. Технологийн хэрэглээг зөв зохистой хэрэглэх
4. Багшийн ёсзүй, харилцаа хандлагын талаарх мэдээллийг улирал бүр тогтмол хийж хэвших
5. Хүүхдэд ээлтэй сэтгэлзүйн таатай орчин бүрдүүлэх
6. Багш нарт блюпринтийн дагуу даалгавар хэрхэн боловсруулах талаар сургалт зохион байгуулах

# АНХААРАН СОНССОН ТА БҮХЭНДЭЭ БАЯРЛАЛАА.